



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.УРТНАСАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2021.09.13 № 33

Асуулга тавих тухай

Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргаас тус сумын газар нутагт хамаарах Говийн Их Дархан Цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааг Байгаль орчны сайдын 2021 оны А/45 дугаар тушаалаар Зүүн гарын дархан цаазат газар болгон өөрчилж, захиргааг нь Ховд аймгийн Алтай сум руу шилжүүлсэн талаарх албан бичгийг миний нэр дээр ирүүлсэн.

Засаг даргын албан бичигт "... дархан газрын захиргааг нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотой Бугат сумын газар нутагт хамаарах дархан цаазат газарт ордог 616.562 га газар тусгай хамгаалалтаас гарах сөрөг нөлөөлөл бий болсон. Сум орон нутгаас дархан газрын захиргааны үйл ажиллагааг байнга дэмжин хөрөнгө оруулалт хийж хэвийн ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж байдаг..." тухай дурджээ.

Говь-Алтай аймгийн Бугат сумын Биж баг /Тахийн тал/ дахь Говийн Их Дархан Цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааг Зүүн гарын дархан цаазат газар болгон өөрчилж Ховд аймгийн Алтай сум руу шилжүүлсэнтэй холбоотой нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сөрөг мэдээллүүд цацагдах, нүүлгэн шилжүүлэх асуудлаар орон нутгийн иргэдийн бухимдал хүрээгээ тэлж байгаа зэрэг эрсдэлт орон зай үүсч байна. Мөн иргэдээс энэ асуудлыг таслан зогсооход Говь-Алтайчуудыг төлөөлөн сонгогдсон УИХ-ын гишүүний хувьд холбогдох арга хэмжээг авах талаар өргөдөл, хүсэлтүүдийг ирүүлээд байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүн би Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Говь-Алтай аймгийн Бугат сумын газар нутагт хамаарах Говийн Их Дархан Цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааг Зүүн гарын дархан цаазат газар болгон өөрчилж, захиргааг Ховд аймгийн Алтай сум руу шилжүүлэх болсон нь шинжлэх ухааны болон эдийн засгийн тооцоололд суурилсан эсэх;

2020000199


2. Говийн Их Дархан Цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа Ховд аймгийн Алтай суманд шилжин очсоноор тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, судалгаа шинжилгээний ажил явуулах үйл ажиллагаанд чанарын ямар дэвшил гарах болсон талаар;

3. Говийн Их Дархан Цаазат газрын "Б" хэсэгт тахь сэргээн нутагшуулахад "Олон улсын тахь судлал" төсөл 1999 оноос эхлэн техник, тоног төхөөрөмжөөр хангаж, холбогдох барилга байгууламжийг барьж үйл ажиллагааг жигдрүүлэн судалгаа, шинжилгээ хийхэд нэлээдгүй хөрөнгө оруулалт хийсэн. Олон улсын төсөл, хөтөлбөр, улсын төсөв, орон нутгийн төсвөөс тус хамгаалалтын захиргаанд өнөөг хүртэл ямар хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн тооцоо судалгааг он дарааллаар гаргаж танилцуулах;

4. Говийн Их Дархан Цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа Ховд аймгийн Алтай суманд шилжин очсоноор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын жагсаалт, хөрөнгө оруулалтын дүнгийн талаарх мэдээлэл.

Асуулгыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд албан бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ЭНХ-АМГАЛАН

2020000189